



МОНГОЛ УЛСЫН  
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН  
ТУШААЛ

2023 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 428

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.7, 14.1.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бөртэ Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Шинэчлэгдсэн дүрмийг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Бөртэ Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (захирал Д.Энхтайван)-т үүрэг болгосугай.
3. Дүрэм батлагдсантай холбогдуулан Батлан хамгаалахын сайдын 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/206 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (хурандаа Н.Пүрэвдорж)-т даалгасугай.

САЙД



Г.САЙХАНБАЯР

1323100670

Батлан хамгаалахын сайдын 2023 оны

11 дугаар сарын 11-ны өдрийн

11 дугаар тушаалын хавсралт

**“БӨРТЭ” ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХҮЙН ТООЦООТ  
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь “Бөртэ” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (цаашид “Бөртэ” ТӨААТҮГ гэх)-ын зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг тодорхойлж, байгууллагын удирдлага, албан тушаалтны эрх, үүргийн хэм хэмжээг тодорхойлох, үйл ажиллагаатай холбогдох бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2. “Бөртэ” ТӨААТҮГ нь Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээний, төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар мөн.

1.3. Байгууллагын оноосон нэр нь “Бөртэ” төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, товчилсон нэр нь “Бөртэ” ТӨААТҮГ байна.

1.4. “Бөртэ” ТӨААТҮГ-ын оноосон нэрийг англи хэл дээр “Burte” State Owned Business settlement Enterprice гэнэ.

1.5. “Бөртэ” ТӨААТҮГ нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Компанийн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай, бусад холбогдох хууль тогтоомж, энэ дүрмийг мөрдөнө.

1.6. “Бөртэ” ТӨААТҮГ нь ашгийн төлөө хуулийн этгээд байна.

1.7. “Бөртэ” ТӨААТҮГ нь тогтоосон стандартад нийцсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд байгууллагын онцлогийг илэрхийлсэн бэлгэдэлтэй байна.

1.8. “Бөртэ” ТӨААТҮГ-ын бэлгэдлийн загварыг ерөнхий захирал баталж, холбогдох хууль тогтоомжийн дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газар, Оюуны өмчийн газарт тус тус бүртгүүлсэн байна.

1.9. “Бөртэ” ТӨААТҮГ-ын төв байр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод байрладаг. Албан ёсны хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Төмөрчний гудамж.

Хоёр. Үйл ажиллагааны үндсэн чиглэл, чиг үүрэг

2.1. “Бөртэ” ТӨААТҮГ-ын үндсэн үйл ажиллагаа нь Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб болон бусад Төрийн цэргийн байгууллагуудын захиалгын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан цэргийн алба хаагчдын бүх төрлийн цэргийн дүрэмт хувцас, хэрэглэл, оёмол

бүтээгдэхүүнийг чанар стандартын өндөр түвшинд үйлдвэрлэн бэлтгэн нийлүүлэхэд чиглэгдэнэ.

2.2. “Бөртэ” ТӨААТҮГ нь цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийг үйлдвэрлэн нийлүүлэх оюуны өмчийн тусгай зөвшөөрөл эзэмшинэ.

2.3. “Бөртэ” ТӨААТҮГ нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.3.1. бүх төрлийн дүрэмт хувцас, хэрэглэл, оёмол бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, захиалагчид нийлүүлэх,

2.3.2. дайчилгааны даалгаврын хэрэгжилтийг хангах, бүтээгдэхүүн, материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, шаардлагатай үед цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийг үйлдвэрлэх,

2.3.3. үйлдвэрийн үйл ажиллагааг бизнесийн түвшинд өргөжүүлэх, дэвшилтэт техник, технологи, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлд нэвтрүүлж ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх,

2.3.4. төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг Батлан хамгаалах яамны захиалга, даалгавраар болон бие даан зохион байгуулах, гүйцэтгэх,

2.3.5. үйлдвэрийн хэрэгцээ шаардлагын дагуу мэргэжлийн ажилтан албан хаагчийг-бэлтгэх, сурган дадлагажуулах, хөгжүүлэх,

2.3.6. үйлдвэрийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэн, байгууллагын цэвэр ашгаас Зэвсэгт хүчний хөгжлийн санд хөрөнгө төвлөрүүлэх,

2.4. “Бөртэ” ТӨААТҮГ нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд дараах үйл ажиллагааг явуулна.

2.4.1. үндсэн чиг үүргийн хүрээнд хамтран ажиллах төрийн болон төрийн бус байгууллагуудтай бүтээгдэхүүний захиалгын хэлцэл хийх, гэрээ байгуулах, хэрэгжүүлэх,

2.4.2. захиалагчид бэлтгэн нийлүүлэх, худалдан борлуулах, ажил үйлчилгээг үзүүлэх, хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа (нэрийн барааны дэлгүүр, мал аж ахуй, цайны газар, жимс жимсгэнэ тариалах, хүлэмжийн аж ахуй, газар тариалан, гар урлалын зүйлс хийх, амралтын газар) эрхлэн явуулах, өргөжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх

2.4.3. бизнесийн шинэ чиглэлийг эрэлхийлэх, сонгох, хэрэгжүүлэх, төсөл, хөтөлбөрийн техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулах

2.4.4. үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гадаад, дотоод зах зээлийн судалгаа хийх, үйл ажиллагааг өргөжүүлэх, хөгжүүлэх

2.4.5. бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, материал хэрэглэлийг гадаад, дотоод зах зээлээс худалдан авах, ханган нийлүүлэх ажлыг зохион байгуулах, гүйцэтгэх

2.4.6. орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, үйл ажиллагаандаа ашиглах, мэргэжлийн их дээд сургууль, сургалтын байгууллагуудтай хамтран ажиллах, туршлага судлах

2.4.7. ажиллагсдын нийгмийн хамгааллыг сайжруулахад чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцох

2.4.8. мэргэжлийн байгууллагуудтай хамтран батлан хамгаалах зориулалттай бараа, ажил, үйлчилгээний чанар, стандарт, гүйцэтгэлд хяналт тавих

2.4.9. төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх

2.4.10. үндсэн хөрөнгө болон үндсэн хөрөнгийн шинж чанартай, өндөр үнэ бүхий эргэлтийн хөрөнгийг акталж, устгах, шилжүүлэх болон шинээр худалдан авах,

асуудлыг Захирлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх

2.4.11. үйлдвэрийн ачаалал, ажиллах хүчний хүрэлцээнээс хамааран зарим нэр төрлийн ажил, үйлчилгээг Захиалагчийн зөвшөөрлөөр Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болно.

2.4.12. тайван цагт өөрийгөө санхүүжүүлэн үр ашигтай ажиллаж, бизнес төлөвлөгөөний дагуу үйлдвэрийн үйл ажиллагаанд захиран зарцуулах.

Гурав. “Бөртэ” ТӨААТҮГ-ын зохион байгуулалтын бүтэц

3.1. “Бөртэ” ТӨААТҮГ нь зохион байгуулалтын бүтэцдээ Захиргаа, аж ахуйн алба, Үйлдвэрлэлийн алба, Санхүүгийн алба гэсэн үндсэн нэгжүүдтэй байна.

3.2. “Бөртэ” ТӨААТҮГ нь төрийн болон өөрийн хөрөнгө, хөрөнгө оруулалтаар байгуулсан үйлдвэрлэл, үйлчилгээний салбартай байж болно.

Дөрөв. “БӨРТЭ” ТӨААТҮГ-ын удирдлагын эрх, үүрэг

4.1. “Бөртэ” ТӨААТҮГ нь үндсэн зорилгоо хэрэгжүүлэхдээ хамтын удирдлага, ил тод байдлыг эрхэмлэн захирлын зөвлөлтэй байх ба зөвлөлийн шийдвэрээр үйлдвэрийн үйл ажиллагаатай холбоотой тулгамдсан асуудлыг шийдвэрлэнэ.

4.2 Үйл ажиллагааны төсвийн төсөл, төсөөллийг Монгол Улсад дагаж мөрддөг нэгдсэн аргачлалаар байгууллагын ойрын, дунд, урт хугацааны хөгжлийн зорилго, зорилтуудтай уялдуулан боловсруулна.

4.3 “Бөртэ” ТӨААТҮГ-ын ерөнхий захирал нь холбогдох хууль тогтоомж, албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан, цэргийн дээд боловсролтой, батлан хамгаалах салбарт 20-иос доошгүй жил тасралтгүй ажилласан, аж ахуй, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх зохих мэдлэг, ур чадвар байна.

4.4 “Бөртэ” ТӨААТҮГ-ын Ерөнхий захирал нь холбогдох хууль тогтоомжид зааснаас гадна дараах эрхтэй.

4.4.1.хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр иргэнийг ажилд авах, сэлгэх, өөр ажилд түр шилжүүлэх, чөлөөлөх, халах

4.4.2.иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, сунгах, цуцлах, дуусгавар болгох, биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэх

4.4.3.“Бөртэ” ТӨААТҮГ-ыг хуульд заасны дагуу итгэмжлэлгүйгээр төлөөлөх эсхүл өөрийн шийдвэрээр итгэмжлэлийн үндсэн дээр эрх бүхий этгээдээр төлөөлүүлэх

4.4.4.холбогдох хууль тогтоомж, энэ дүрэмд заасны дагуу “Бөртэ” ТӨААТҮГ-ыг төлөөлөн төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах санамж бичиг, гэрээ байгуулах

4.4.5.“Бөртэ” ТӨААТҮГ-ын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг батлах, мөрдүүлэх

4.4.6 “Бөртэ” ТӨААТҮГ-ын төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх

4.4.7.албан тушаалын тодорхойлолтыг батлах

4.4.8.албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заагдсан чиг үүргээ хэрэгжүүлэхийг ажилтан, алба хаагчаас шаардах, тэдэнд хууль ёсны шаардлага тавих

4.4.9.ажилтан, алба хаагчид холбогдох хууль тогтоомжид заасны дагуу цалин хөлс, нэмэгдэл, үйлдвэрийн ашгаас тодорхой хувиар үр дүнгийн урамшуулал, шагналт цалинг энэ дүрмийн 4.2-т заасан зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн олгох, урамшууллын хэмжээг тогтоож, мөрдүүлэх

4.4.10.бие бүрэлдэхүүний ажиллах таатай орчин, нөхцлийг бүрдүүлэх

4.4.11.холбогдох хууль тогтоомжийн хүрээнд байгууллагын үл хөдлөх хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх, ашиглуулах

4.4.12.холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд “Бөртэ” ТӨААТҮГ-ын үйл ажиллагаанд дотоодын болон хөндлөнгийн шалгалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх.

4.5.“Бөртэ” ТӨААТҮГ-ын Ерөнхий захирал нь холбогдох хууль тогтоомжид зааснаас гадна дараах үүрэгтэй.

4.5.1.“Бөртэ” ТӨААТҮГ-ын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан, зохион байгуулах

4.5.2.бие бүрэлдэхүүнд хуульд нийцсэн үүрэг, даалгавар өгөх, биелэлтийг хангуулах

4.5.3.“Бөртэ” ТӨААТҮГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөө, бизнес төлөвлөгөөг боловсруулан жил бүр Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлгнах

4.5.4.“Бөртэ” ТӨААТҮГ-ын бүтэц, орон тооны саналаа Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэрлүүлэх

4.5.5.дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах

4.5.6.төрийн өмчийн ашиглалт, хамгаалалт, хадгалалтыг зохион байгуулах, хяналт тавих

4.6. “Бөртэ” ТӨААТҮГ-ын Захиргаа, аж ахуйн алба нь Үйлдвэрийн үйл ажиллагааг захиргааны удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хүний нөөц, хууль эрх зүй, архив, албан хэрэг хөтлөлт, маркетингийн үйл ажиллагаа, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн стандарт, ар талын хангалтыг тасралтгүй явуулж, ажилтан, алба хаагчийн ажиллах ая тухтай орчин, нөхцөлийг бүрдүүлж ажиллах зорилтын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.6.1. үйлдвэрийн үйл ажиллагааны хууль, эрх зүйн хэм хэмжээг сахиулах, байгууллагын дүрэм, хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангах, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах

4.6.2. хууль, тогтоомж, удирдах дээд шатны байгууллагуудын тушаал, шийдвэр, тогтоол, Ерөнхий захирлын тушаал, шийдвэр, нэмэлт үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах, гүйцэтгэлийг тайлгнах;

4.6.3. үйлдвэрийн бүтцийн нэгжүүдийн ажлыг уялдуулан зохицуулах, албадын дарга нарын шуурхай зөвлөгөөнийг удирдан зохион байгуулах, түүний шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах;

4.6.4. гадаад болон дотоод зах зээлийг судлах, байгууллагын маркетингийн бодлогыг зөв тодорхойлж, бизнесийн үйл ажиллагаанд чиглүүлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх

4.6.5. үйлдвэрийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэх, нөхөн хангах, ажилтан, албан хаагчийн нийгмийн асуудлыг сайжруулахад чиглэсэн санал боловсруулж, хэрэгжүүлэх

4.6.6. архив, албан хэрэг хөтлөлт, нууц хадгалалт, хамгаалалтыг байгууллагын хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;

4.6.7. ажлын байрны хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартын шаардлагыг хангаж ажиллах

4.6.8. ар талын хангалтыг цаг хугацаанд нь тасралтгүй зохион байгуулж үйлдвэрийн үйл ажиллагааг хэвийн явагдах боломжийг хангах, ажилтан, албан хаагчийн ая тухтай ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэх.

4.7. "Бөртэ" ТӨААТҮГ-ын үйлдвэрлэлийн алба нь Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчин болон бусад Төрийн цэргийн байгууллагуудын цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн баталсан зарлиг, оюуны өмчийн эрхийн гэрчилгээ, техникийн бичиг баримтыг үндэслэн загвар, технологийн дагуу үйлдвэрлэн, цаг хугацаанд нь нийлүүлэн ажиллах зорилтын хүрээнд дараах чиг үүрэгтэй байна.

4.7.1.цэргийн дүрэмт хувцсыг чанартай материал хэрэглэлээр загвар, технологийн дагуу үйлдвэрлэх

4.7.2.үйлдвэрлэлд ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн урсгал засварыг тогтмол гүйцэтгэх, хэвийн үйл ажиллагааг хангах

4.7.3.шинэ дэвшилтээ техник, технологийг нэвтрүүлэх, оёдлын дамжлагын гар ажиллагааг багасгах, бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх

4.7.4.үйлдвэрлэлийн ажилчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, шинээр сургах, дадлагажуулах чиглэлээр сургалт зохион байгуулах.

4.8. Санхүүгийн алба нь "Бөртэ" ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, Батлан хамгаалахын сайдын тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, өмч, хөрөнгө хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад хяналт тавих, тайлан тэнцлийг хуулийн хугацаанд гаргаж, үр ашигтай ажиллаж, өр авлага үүсгэхгүй, санхүүгийн үйл ажиллагааг жигд, тасралтгүй явуулах, үйлдвэрлэлийг хэрэгцээт бараа материалаар хангах зорилтын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.

4.8.1. "Бөртэ" ТӨААТҮГ-ын санхүү, төсвийн үйл ажиллагааг Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллах

4.8.2.төсвийн хэрэгжилтэд хяналт тавих, санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлж, зарцуулалтыг оновчтой хэрэгжүүлэх, дүн шинжилгээ хийх

4.8.3.өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр хяналт тавих, ашиглалтыг сайжруулах

4.8.4.санхүүгийн тайлан мэдээг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох байгууллагад тайлагнах

4.8.5.үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шаардлагатай бараа, материалыг худалдан авах ажлыг зохион байгуулах

4.8.6.өр, авлагыг барагдуулах

4.8.7.амралтын газрын үйл ажиллагааг удирдах, маркетинг сурталчилгааг идэвхжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх.

4.9. "Бөртэ" ТӨААТҮГ-ын Санхүүгийн албаны дарга-ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн нягтлан бодогч байна.

Тав. Хамтын ажиллагаа

5.1. “Бөртэ” ТӨААТҮГ нь дотоод, гадаадын хамтын ажиллагааг эрхлэн явуулахдаа Монгол Улсын хууль тогтоомж, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон дүрэм, журам, олон улсын гэрээг баримтална.

5.2. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон эрх хэмжээний хүрээнд гадаад улс орны холбогдох хуулийн этгээдтэй харилцана.

5.3 “Бөртэ” ТӨААТҮГ нь Батлан хамгаалах яамны харьяа агентлаг, аж ахуйн нэгж, байгууллагуудтай бие дааж харилцана.

5.4. “Бөртэ” ТӨААТҮГ нь дотоод, гадаадын ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг үйлдвэр, аж ахуйн газартай дараах чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлнэ:

- 5.4.1. хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр байгуулах
- 5.4.2. хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх
- 5.4.3. оёмол бүтээгдэхүүн, материал хэрэгслийн худалдаа эрхлэх
- 5.4.4. шинэ техник, технологийг нэвтрүүлэх
- 5.4.5. хөрөнгө оруулалт төвлөрүүлэх
- 5.4.6. үзэсгэлэн худалдаа зохион байгуулах
- 5.4.7. дотоод, гадаадын тендерт оролцох.

#### Зургаа. Дүрмийн сан

6.1. “Бөртэ” ТӨААТҮГ-ын дүрмийн сан нь зөвхөн төрийн өмчийн эд хөрөнгөөс бүрдэх бөгөөд нийт хэмжээ 733, 445, 573,35 /Долоон зуун гучин гурван сая дөрвөн зуун дөчин таван мянга таван зуун далан гурван төгрөг гучин таван/ мөнгө байна.

#### Долоо. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаа

7.1. “Бөртэ” ТӨААТҮГ нь өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлнэ.

7.2. “Бөртэ” ТӨААТҮГ -ын орлого нь дараах санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ:

- 7.2.1. бараа, ажил, үйлчилгээнээс олсон орлого
- 7.2.2. банкны хадгаламжийн данс дахь хүү
- 7.2.3. хандив, зээл, тусlamж, хөрөнгө оруулалт
- 7.2.4. хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр.

7.3. Байгууллагын батлагдсан орлогын төлөвлөгөөг ханган биелүүлж, зардлыг хэмнэлттэйгээр үр ашигтай зарцуулна.

7.4. “Бөртэ” ТӨААТҮГ-ын санхүүгийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.

7.5. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр хяналт тавина.

7.6. Жилийн эцсийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, Батлан хамгаалахын сайдын тушаалаар баталсан холбогдох дүрэм, журмын дагуу гаргаж, аудит хийлгэнэ.

- 7.7. Санхүүгийн тайландаа зүйлийг тусгана:
  - 7.7.1. санхүүгийн байдлын тайлан
  - 7.7.2. орлогын дэлгэрэнгүй тайлан;
  - 7.7.3. мөнгөн гүйлгээний тайлан;
  - 7.7.4. өмчийн өөрчлөлтийн тайлан;
  - 7.7.5. тайлангийн тодруулга.

#### Найм. Үйлдвэрийн газрын хяналт

8.1.“БӨРТЭ” ТӨААТҮГ-ЫН бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, сахилга, хариуцлагыг бэхжүүлэх зорилгоор дотоод хяналтыг хэрэгжүүлнэ.

8.2.“БӨРТЭ” ТӨААТҮГ-ЫН дотоод хяналтын ажилтан нь дараах үүргийг биелүүлнэ.

8.2.1.Бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан холбогдох зорилт, арга хэмжээ, хууль тогтоомж, удирдлагын баримт бичгийн хэрэгжилт, явцыг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хянах;

8.2.2.“БӨРТЭ” ТӨААТҮГ-ЫН гүйцэтгэлийн болон бизнес төлөвлөгөөний хэрэгжилт, явцыг төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн эсэхэд хяналт тавьж, үнэлгээ өгөх;

8.2.3.Бодлогын зорилт, төлөвлөсөн арга хэмжээнүүд нь зорилтот түвшиндээ хүрээгүй эсвэл удаашралтай байгаа тохиолдолд шалтгаан нөхцөлийг тодорхойлж, тэдгээрийг эрчимжүүлэх, үр дүнг сайжруулах талаар дүгнэлт, зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих

#### Ес. Дүрэм зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

9.1. Энэ дүрмийг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ

#### Арав. Бусад зүйл

10.1. “Бөртэ” ТӨААТҮГ-ЫН дүрэм нь Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгднө.

10.2. .“Бөртэ” ТӨААТҮГ-ЫН ажилтан, алба хаагч энэ дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаж болно.

10.3. Энэ дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг байгууллагын нийт бие бүрэлдэхүүний хуралдаанаар хэлэлцүүлж, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан бичгээр хүргүүлж, шийдвэрлүүлнэ.